



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/112

Хужирт сум

Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21.1.57 дахь хэсэг, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21.1.57-д тусгагдсан “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицолын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх турших нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан Лэгшидийн Зориг (ЙС72062231)-ийн эзэмшлийн 6211000312 нэгж талбарын дугаартай Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалттай 660 м² газрын хэмжээг 632 м² болгон эзэмшсэн газрын мэдээллийг өөрчилсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2015 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн “Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай” А/123 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

3. Шинээр газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

620100223